



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/394

Номгон


Согтууруулах ундаа худалдах тусгай
зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.4, 16 дугаар зүйлийн 16.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу Бууцагаан сумын "Аз дүүрэн нар" ХХК-ний Аз дүүрэн, "Баянхүрэм хайрхан" ХХК-ний Жаргалант хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс 2029 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэр, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн худалдаалахыг аж ахуйн нэгжийн захирал М.Батболд, Б.Түвшинбаяр нарт, холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль,эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

824010979